



“МОНГОЛ БАЗАЛЬТ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 03-р сарын 15-ны өдөр

№. 01

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай


Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дах заалтууд, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, “Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6 дугаар бүлгийн 6.2, 6.3, 6.2, 6.4 дах заалтууд, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 03-р сарын 15-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Монгол базальт” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2021 оны 04 сарын 26-ны өдрийн Даваа гаригийн 16.00 цагт зарлан хуралдуулахаар шийдвэрлэсүгэй.
2. Ковид-19 цар тахлын дотоодын халдварт нэмэгдэж байгаатай холбогдуулан нэг дор олон хүн цугларахгүй байж эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдааныг онлайн орчинд буюу MI SURVEY программ ашиглан явуулахаар тогтсугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
 1. “Монгол базальт” ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж, батлах
 2. “Монгол базальт” ХК-ийн дүрэмийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэж, батлах
 3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох

4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2021 оны 04 сарын 08-ны өдрөөр тогтоосугай.
5. "Монгол базальт" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах хурлын зарыг 2021 оны 03 сарын 20-ний өдөр Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас, Компанийн өөрийн цахим хуудас, өдөр тутмын нэг сонин, радио, телевизийн аль нэгээр мэдээлсүгэй.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах давтан зарыг 2021 оны 04 сарын 04-ний өдөр анх мэдээлсэн хэлбэрээр өдөр тутмын сонин болон радио телевизийн аль нэгээр мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
7. Хувьцаа эзэмшигч нь энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтад заасан бичиг баримтуудыг 7 хоног бүрийн ажлын өдрүүдийн 11.00-16.00 цагийн хооронд Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, "Фламинго тауэр"ийн 7 давхарт ирж танилцаж болох ба үйлчлүүлдэг үнэт цаасны компанидаа хандах авах боломжтой болохыг дурьдсугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх материал, энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтад заасан баримт бичгийг бэлэн болгох эцсийн хугацааг 2021 оны 03 сарын 21-ний өдрөөр тогтоосугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудал, хурлаас гаргах тогтоолын төсөл, түүнтэй холбоотой материалыг олон нийтэд хурлын зар хүргэнээс хойш 5 хоногийн дотор хувьцаа эзэмшигч наарт үйлчилж буй Үнэт цаасны компаниудад хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлсүгэй.
- 10.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
- 11.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг гуравдугаар хавсралтаар баталсугай.
- 12.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах "Саналын хуудас"-ны агуулгыг дөрөвдүгээр хавсралтаар баталсугай.
- 13.Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох боломжгүй урьдчилан саналын хуудасаар санал өгөх хувьцаа эзэмшигчдийн саналын хуудасыг хүлээн авах сүүлийн өдрийг 2021 оны 04 сарын 08-ны өдрөөр тогтоосугай.

14. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар А.Энхгэрэл, хурал зохион байгуулах комиссын гишүүдээр Б.Амаржаргал, Б.Номун нарыг тус тус томилсугай.
15. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар Ц.Байгалмаа, тооллогын комиссын гишүүдээр Б.Болортuya, Б.Уранбилэг нарыг тус тус томилсугай.

ЗӨВШӨӨРСӨН:



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

..... / Г.Ганзориг /

..... / А.Энхгэрэл /

..... / П.Сайнбилэг /

..... / Б.Шаравсамбуу /

..... / Хан Гю Бунг /

..... / Ш.Энхтөр /

..... / Ч.Зоригтбаатар /

..... / Т.Цэнд-Аюуш /